



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 1/58

Пионер толгой

Дархлаажуулалтын ажил зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг дахиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.5, 9.8, 20 дугаар зүйл, Улсын онцгой комиссын 2022 оны 02 дугаар сарын тогтоол, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2022 оны А/77 дугаар тушаал, аймгийн онцгой комиссын 2022 оны 04/06, 11 дүгээр хуралдааны тэмдэглэл, аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 19 өдрийн А/249 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт, Олон Улсын худалдааны хорио цээрт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын аяныг 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд яаралтай зохион байгуулсугай.

2. Мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын ажлыг яаралтай зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Дархлаажуулалтын ажилд мал сүргээ бүрэн хамруулж, хашаа хороо, хүн хүчээр хангаж, дархлаа тогтоох хүртэл 14 хоногийн хугацаанд нүүдэл хийхгүй байх, дархлаажуулалтад мал сүргээ бүрэн хамруулах ажлыг багийн Засаг дарга нарт, төлөвлөгөөт дархлаажуулалтын ажилд мал сүргээ хамруулахаас зайлсхийсэн, санаатай болон санамсаргүй байдлаар шилжилт хөдөлгөөн хийсэн нөхцөлд хариуцлага тооцож ажиллахыг хэсгийн төлөөлөгч, ахлах дэслэгч (Л.Дуламдорж)-д үүрэг болгосугай.

4. Мал, амьтны гоц халдварт, Олон Улсын худалдааны хорио цээрт шүлхий өвчний дархлаажуулалт хийсэн бүс нутгаас 28 хоногийн хугацаанд мал, амьтан болон тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн гаргахгүй байх, Мал эмнэлгийн гэрчилгээ бичихгүй байхыг Мал эмнэлгийн аж ахуйн нэгжийн эмч нарт, хэсгийн төлөөлөгч, ахлах дэслэгч (Л.Дуламдорж) нарт тус тус үүрэг болгосугай.


647101211

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Р.Гантулга)-д даалгасугай.



ДАРГА *Р.Гантулга* Б.ГАНТУЛГА

Сумын Засаг даргын 2022 оны 04 дүгээр  
сарын 20-ны өдрийн захирамжийн  
хавсралт



МАЛ АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС  
СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЖИЛ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Цэнгэл 1-дүгээр багт ажиллах ажлын хэсэг

1. Багийн Засаг дарга Б.Лувсаншийрэв
2. Хөгжил дэвшил нэгдэл-Мал эмнэлгийн эрхлэгч, их эмч Б.Бат-Эрдэнэ

Давааны ам 2-дугаар багт ажиллах ажлын хэсэг

1. Багийн Засаг дарга Д.Мөнхчулуун
2. Хөгжил дэвшил нэгдэл-Мал эмнэлгийн эрхлэгч, их эмч Б.Бат-Эрдэнэ

Буга 3 дугаар багт ажиллах ажлын хэсэг

1. Багийн Засаг дарга Д.Болд-Аюуш
2. Морин мөрт-Мал эмнэлгийн эрхлэгч, их эмч С.Цэнд-Аюуш

Хөвийн ам 4-дүгээр багт ажиллах ажлын хэсэг

1. Багийн Засаг дарга Б.Баттулга
2. Морин мөрт-Мал эмнэлгийн эрхлэгч, их эмч С.Цэнд-Аюуш

Пионер толгой 5-дугаар багт ажиллах ажлын хэсэг

1. Багийн Засаг дарга Ч.Батцэцэг
2. Морин мөрт-Мал эмнэлгийн эрхлэгч, их эмч С.Цэнд-Аюуш

Гүйцэтгэлийн хяналтын ажлын хэсэг

Засаг даргын орлогч Э.Сүглэгмаа  
Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч Э.Хас-Очир  
Хэсгийн төлөөлөгч Л.Дуламдорж  
БОХУ-ын байцаагч Ш.Нархүү